

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын 15

Дугаар 36

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.3 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, дүүргийн Засаг даргын 2022 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 01/218 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зургадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий “Орон нутгийн санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоол батлагдсантай холбогдуулан тус журмыг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлэхийг Хурлын Ажлын албанд даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Ч.Мэндсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГА

А.БАЯР

ОРОН НУТГИЙН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ОРОН НУТГИЙН САНГИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалтууд нь энэхүү журмын зохицуулалтын эрх зүйн үндэслэл болно.

1.2. Орон нутгийн хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий төсвийн бус хөрөнгөөс бүрдсэн, орон нутгийн хөрөнгийг төлөвлөх, бүрдүүлэх, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тооцох, түүнд хяналт тавихад энэхүү журмыг мөрдөнө.

1.3. Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих, урьдчилан төлөвлөн нарийвчлан тооцож төсөвт тусгах боломжгүй хүчин зүйлээс шалтгаалан төсвийн жилийн явцад шаардагдаж болзошгүй төсвийн зардлыг нөхөн санхүүжүүлэх, төсвийн бус орлогын эх үүсвэрийг санаачлан бүрдүүлэхэд Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих сан (цаашид “Орон нутгийн сан” гэх)-ийн зорилго оршино.

Хоёр. Орон нутгийн сангийн эх үүсвэр

2.1. Орон нутгийн сангийн орлого нь дараахь эх үүсвэрүүдээс бүрдэнэ.

2.1.1. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухайн жилийн үйл ажиллагааны цэвэр ашгийн 20 хүртэл хувь (тухайн жилийн эцэст);

2.1.2. Гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн бүх төрлийн хандив, тусламж;

2.1.3. Орон нутгийн төрийн байгууллагаас хуулиар хориглоогүй асуудлаар аж ахуйн үйл ажиллагаа явуулж олсон орлого.

Гурав. Орон нутгийн үйл ажиллагааг дэмжих сангийн төлөвлөлт, зориулалт

3.1. Орон нутгийн санг орон нутгийн чиг үүргийг гүйцэтгэх хүрээнд тухайн орон нутгийн төсвийн бус орлогоос бүрдүүлэх боломж, чадавхийг харгалзан тухайн жилийн төсөвт урьдчилан төлөвлөж тусгах боломжгүй, санхүүгийн эх үүсвэр дутмаг байгаа дор дурдсан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулан төлөвлөнө.

3.1.1. Орон нутгийн үндсэн чиг үүрэгт хамаарах аливаа төсөл, арга хэмжээ;

3.1.2. Төсвийн жилийн дундуур шинээр ашиглалтад орсон барилга, байгууламжийн үйл ажиллагааны болон ашиглалтын зардлыг санхүүжүүлэх;

3.1.3. Урьдчилан тооцох боломжгүй, цаг үеийн шинжтэй зарим асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах зардал (төсөвт тусгагдаагүй гадаад, дотоодын зочин, төлөөлөгчдийг хүлээн авахтай холбогдсон зардал, олон улсын болон улс, орон нутгийн чанартай уралдаан тэмцээнд оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлэх зардал гэх мэт);

3.1.4. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагуудаас тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх;

3.1.5.Орон нутгийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын шаардлагатай төсөл арга хэмжээг санхүүжүүлэх;

3.1.6.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тэгш ойг тэмдэглэн өнгөрүүлэх зардлыг санхүүжүүлэх;

3.1.7.Газар тариалан эрхлэх, ойжуулалтыг бий болгоход санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.1.8.Цөлжилтийг бууруулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх;

3.1.9.Орон нутагт нэн шаардлагатай мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд сургалтын төлбөрийг санхүүжүүлэх, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж амьдрахад шаардагдах дэмжлэг үзүүлэх;

3.1.10.Аймаг, орон нутгийн нэрийг тив, дэлхий, улсын хэмжээнд гаргасан иргэдийг шагнах, урамшуулах, хүндэтгэл үзүүлэх;

3.1.11.Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх.

3.2.Орон нутгийн сангийн орлогын хэмжээг энэхүү журмыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар нийт дүнгээр нь орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгон батална.

Дөрөв. Сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэр гаргахад тавигдах шаардлага, хориглолт

4.1.Сангийн хөрөнгийг зарцуулах тухай Засаг даргын шийдвэрийн төсөл нь дор дурдсан шаардлагыг хангасан байна.

4.1.1.шийдвэрийн төсөл нь энэ журмын 3.1-д заасан зориулалттай бүрэн нийцсэн болохыг танилцуулгад тодорхой тусгасан байх;

4.1.2.сангийн хөрөнгийг зарцуулах үндэслэл, шаардлага, үр дүнг шийдвэрийн төслийн танилцуулгад тодорхой дурдсан байх;

4.1.3.арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг зөв, бодитой тооцсон эсэхийг холбогдох норм, норматив, тариф, бусад баримтаар нотолсон байх;

4.1.4.хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хандивлагчаас гаргасан хүсэлт зэргийг шийдвэрийн төсөлд хавсаргасан байх.

4.2.Тухайн жилд орон нутагтай холбоотой үйл ажиллагаанд гэрээ, хэлцэл байгуулан ажиллаж байгаа болон эрх бүхий шийдвэр гаргуулахаар хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдээс хандив тусламж авахыг хориглоно.

Тав. Орон нутгийн сангаас хөрөнгө зарцуулах шийдвэр

5.1.Орон нутгийн сангаас хөрөнгө зарцуулахдаа тухайн шатны Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хурлын шийдвэрийг үндэслэж захирамж гарган шийдвэрлэнэ.

5.2.Орон нутгийн сангаас хөрөнгө гаргах тухай шийдвэрт заагдсан хөрөнгийн хэмжээ нь Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т заасан “шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар” буюу 20.000.000 (хорин сая) төгрөгөөс хэтрэхгүй байна.

Зургаа. Орон нутгийн санг санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тооцох

6.1.Орон нутгийн сангаас зардал гаргах шаардлага гарсан нөхцөлд төсөл, арга хэмжээг санаачилсан, хариуцан гүйцэтгэх байгууллага, ажилтан нь холбогдох төсөл,

төлөвлөгөө, төсвийг зардлын эдийн засгийн ангилалаар хийсэн дэлгэрэнгүй тооцоог дүүргийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

6.2.Засаг даргын Тамгын газар нь ирүүлсэн төсөл, арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, журам болон тухайн үеийн зах зээлийн үнэ ханштай нийцэж байгаа эсэх, уг арга хэмжээ, төсөлд орон нутгийн сангаас хөрөнгө гаргах зайлшгүй шаардлагатай эсэхийг хянан үзэж, холбогдох газар, хэлтсээс санал авч хянуулан, Засаг даргын зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлж захирамж гаргуулна.

6.3.Засаг даргын захирамжийг үндэслэн Санхүү, төрийн сангийн хэлтэс санхүүжилтийг олгоно. Санхүүжилтийг уг төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн онцлог, үе шатны ажлын гүйцэтгэлтэй уялдуулан бүрэн болон хэсэгчлэн олгож болно. Хэрэгжүүлж буй арга хэмжээ, төслийн онцлогоос шалтгаалан эхний ээлжинд зарим бэлтгэл ажил (материал, түүхий эд бэлтгэх гэх мэт) хийгдэх бол урьдчилгаа олгож болох бөгөөд урьдчилгааны хэмжээ нийт зардлын 40-60 хувьд байж болно.

6.4.Тухайн төсөл, арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш 15 хоногийн дотор гаргаж, дүүргийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

6.5.Зардлын тайланг уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсөвтэй зэрэгцүүлэн гаргаж, байгууллагын дарга, нягтлан бодогч нар гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байхаас гадна үндсэн баримтын нэг хувийг хавсаргана.

6.6.Орон нутгийн сангийн эх үүсвэрээр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага нь зардлыг зохих шийдвэрт заасан хэмжээнээс хэтрүүлсэн тохиолдолд тухайн төрийн сангаас нэмж санхүүжилт олгохгүй, харин хэмнэлт гарсан бол холбогдох дансанд эргүүлэн шилжүүлнэ.

Долоо.Тайлагнал, ил тод байдал, хяналт

7.1.Орон нутгийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт нэгтгэн хагас бүтэн жилээр тутамд олон нийтэд нээлттэй тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлнэ.

7.2.Орон нутгийн сангийн зарцуулалтын жилийн эцсийн тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

7.3.Орон нутгийн сангийн жилийн эцсийн зарцуулалтын тайланг аудитын дүгнэлтийн хамт уг тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор байгууллагын шилэн данс, цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

7.4.Дүүргийн Засаг даргын Тамгын газар орон нутгийн сангийн зарцуулалтад хяналт тавьж, зардлын гүйцэтгэл, эх үүсвэрийн үлдэгдлийн мэдээг тооцон гаргаж, дүнг тухайн жилийн эцсээр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргад танилцуулна.

7.5.Төсвийн ерөнхийлөн захирагч нь орон нутгийн үйл ажиллагааг дэмжих сангийн санхүүжилтээр тухайн салбарт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавина.

7.6.Орон нутгийн сангийн гүйцэтгэлд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бүх төрлийн боломжит аргаар хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлнэ.

Найм. Бусад зүйл

8.1.Орон нутгийн сангаас олгосон хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно.

8.2.Зориулалтын бусаар зарцуулсан тохиолдолд тухайн байгууллага төсөвт байгууллага бол батлагдсан төсвөөс нь суутган тооцож, аж ахуйн байгууллага бол тухайн байгууллагын харилцах данснаас үл маргалдах журмаар нөхөн төлүүлэх асуудлыг ажил гүйцэтгэгч, захиалагч байгууллагын хоорондын гэрээ, хэлцэлд тусгасан байна.

8.3.Орон нутгийн сангаас эх үүсвэрийг нь гарган санхүүжүүлж байгаа арга хэмжээ, төслийг хэрэгжүүлэхдээ бараа, материал, ажил, үйлчилгээг тухайн үеийн зах зээлийн үнэ, ханшаас дээгүүр бэлтгэсэн буюу гүйцэтгэсэн, хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, үр ашиггүй зардал гаргасан зэргээр хөрөнгийн ашиглалтад зүй бусаар хандсан тохиолдолд тухайн төсөл, арга хэмжээг хариуцсан төсвийн захирагч, нягтлан бодогч нарт зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулна. Хэрэв уг асуудал нь авлига, ашиг сонирхлын зөрчил болон эрүүгийн шинжтэй байвал хууль, хяналтын байгууллагад шилжүүлнэ.

Ес. Хариуцлага

9.1.Энэ журамд заасныг зөрчиж сангийн хөрөнгийг зарцуулсан, мөн журмын 4.2-т заасныг зөрчиж хандив, тусламж авсан бол хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.